

Нийгэм-эдийн засгийн сэдэвчилсэн газрын зураг зохиоход хэрэглэгдэх зураглалын аргууд

ГМС-Зурагзүйн салбар
ЭШДА Ц.Наранцацрал





Зураг зүй гэж газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцаа хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагаа юм (Монгол улсын Геодези, зураг зүйн тухай хууль).



Зураг зүй нь газрын зургийг хэрхэн яаж боловсруулах тухай технологи, зургийг хэрхэн үзүүлэх тухай урлаг, орон зайн мэдээллийг үр дүнтэй, үнэн зөв, ойлгогдохуйц харуулах тухай шинжлэх ухаан юм. Зураг зүйн хувьд орон зайн мэдээллийг газрын зургаар дамжуулан хялбар ойлгогдохуйц, нэг дор олон мэдээллийг багцалж хэрэглэгчдэд хүргэн, тэдний асуултанд харааны байдлаар болон эмх цэгцтэйгээр үр дүнтэй хариулах нь чухал юм.



Газрын зураг нь:

1. Мэдээллийг бүртгэх, хадгалах хэрэгсэл болж чаддаг .
2. Орон зайн өөрчлөлт, хөдөлгөөн, чиг хандлагыг тодорхойлох, судлахад ашиглагддаг.
3. Мэдээллийг үзүүлэх, дамжуулах үр дүнтэй арга юм.



Газрын зураг нь аливаа юмс үзэгдлийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийг харуулах, тухайн үзүүлэлтийг байгаа эсэхийг харуулах, эсвэл үзүүлэлтийн өсөлт бууралтыг үзүүлэх, түүнтэй хамааралтай бусад хүчин зүйлтэй нь холбон зурагладаг. Ингэснээр газрын зурагт үзүүлсэн мэдээллийг шинжлэн судалж, үнэлэх, учир шалтгааныг илрүүлэх, зурагт тулгуурлан төлөвлөлт, хөгжүүлэлтийг сайжруулах ашиг тустай.



Газрын зураг нь үгээр илэрхийлэхэд хэцүү мэдээллийг дамжуулах, эсвэл үгээр илэрхийлэхэд хэт урт мэдээллийг нягтруулан товчилж бүрэн агуулгыг нь багтаан дүрслэх боломжийг олгодог. Мөн газрын зураг нь өнгө, хэлбэр дүрс, график диаграммаар дамжуулан аливаа хүчин зүйлсийн харилцаа холбоог илүү нарийвчлан дүрсэлдэг.



Сэдэвчилсэн газрын зураг нь тодорхой нэг буюу хэд хэдэн сэдэв, тодорхой өгөгдлийн шинж чанар, орон зайн тархалтыг харуулдаг. Сэдэвчилсэн газрын зураг нь нягтрал, тархалт, харьцангуй хэмжээ, шатлал, хэлбэлзэл, орон зайн харьцаа, хөдөлгөөн зэрэг газарзүйн ойлголтыг харуулдаг.



Нийгэм-эдийн засгийн сэдэвчилсэн зураг нь нийгэм-эдийн засгийн ямарваа нэг үзүүлэлт, өгөгдлийн шинж чанар, орон зайн тархалт, мэдээллийг дүрсэлсэн зураг юм.

Газрын зураг боловсруулах үйл явцын дараалал



Зураглаж буй өгөгдлийн орон зайн байршил, тэдгээрийн шинж чанар, хөгжил хөдөлгөөн, уялдаа холбоог газрын зурагт үзүүлэхэд ашигладаг график аргыг зурагзүйн **зураглалын арга** гэдэг. Газрын зураг боловсруулахад өгөгдлийг үзүүлэх зөв аргыг сонгох нь чухал юм.

Нийгэм-эдийн засгийн зурагт ашигладаг зураглалын аргууд



ТЭМДГИЙН АРГА



ЦЭГЭН АРГА



КАРТОГРАММЫН
АРГА



КАРТОДИАГРАММЫН
АРГА



ИЖИЛ ШУГАМЫН
АРГА



ХӨДӨЛГӨӨНТ
ШУГАМЫН АРГА




АРЕАЛЫН АРГА




ӨНГӨТ
ДЭВСГЭРИЙН АРГА


Тэмдгийн арга: зураглаж буй юмс, үзэгдлийн байршлыг харуулахад өргөн хэрэглэгддэг. Тэмдгүүд нь геометр дүрс, үсгэн тэмдэгт, эсвэл зураглаж буй зүйлийг илэрхийлэх хэлбэр дүрсээр дүрслэгддэг. Тэмдгийн өнгө, хэлбэр, хэмжээ, чиглэл, дүрслэлээр тухайн үзүүлэлтийг орон зайтай нь хамт тодорхой харуулж өгнө.




Картограммын арга: юмс, үзэгдлийн өсөлт, бууралт зэрэг өөрчлөлтийг засаг захиргааны хэгжийн хэмжээнд үзүүлэхэд ашиглагддаг.



Цэгэн арга: юмс, үзэгдлийн байршлын тархалтыг харуулахад ашигладаг. Цэгэн аргыг зураглалд хэрэглэхдээ тодорхой тоон үзүүлэлтийг илтгэх 1 цэгийн хувийн жинг тооцож, орон зайд нь зөв байрлуулан тархаах хэрэгтэй. Цэгүүд нь зургийн суурь өнгөнөөс илүү тод байх ёстой бөгөөд цэгийн хэмжээг зурагт тохируулан сонгоно.




Картодиаграммын арга: юмс, үзэгдлийн тоон болон шинж чанарын үзүүлэлтийг тухайн нутаг дэвсгэрт байгаа тоо хэмжээнд нь тохирох диаграммаар зурж дүрслэх арга. Уг аргаар зураглахдаа засаг захиргааны нэгжийг хамарсан үзэгдэл, хүчин зүйлсийн тоо, чанарын хэмжээг дүрсэлдэг.




Ижил шугамын арга: юмс, үзэгдлийн тодорхой нутаг дэвсгэрт тасралтгүй үргэлжилсэн, өөрчлөгдсөн, тархсан ижил утгатай тоон үзүүлэлттэй цэгүүдийг муруй шугамаар холбон зураглах юм.




Хөдөлгөөнт шугамын арга: юмс, үзэгдлийн орон зайд шилжих хөдөлгөөнийг зураглахад хэрэглэдэг арга. Хөдөлгөөний хурд, чиглэлийг сумаар, явцыг шугамын өргөнөөр үзүүлдэг.



Ареалын арга: юмс, үзэгдлийн тодорхой нутаг дэвсгэрт нэгэн жигд биш хэсэгхэн газарт тархсан байдлыг зурагладаг. Ингэхдээ тархалтын талбай, хилийг тасархай шугам, зураас, цэг, өнгөөр дүрсэлдэг.



Өнгөт дэвсгэрийн арга нь юмс, үзэгдлийн тархалт зураглаж буй нутаг дэвсгэрийг хамарч, нэгэн жигд тархсан байдлыг зураглах арга. Уг аргыг хэрэглэхдээ зураглах гэж буй нутаг дэвсгэрийг нэг ижил шинж чанараар нь хуваан ялган дүрсэлнэ.



Эцэст нь зургийг хэрэглэх, анализ хийж дүгнэхэд дараах шаардлагыг хангасан байх хэрэгтэй:

- ❖ Зурагт үзүүлж буй үзүүлэлт, тоо хэмжээ үнэн зөв, нарийвчлал сайн байх
- ❖ Зурагт үзүүлэлтийг дүрсэлсэн цэг тэмдэг, график, диаграмм, шугам, өнгө дүрс нь тоон мэдээллийг өгөхөөс гадна, зураглаж буй зүйлсийн хоорондын уялдаа холбоог тайлбарладаг тул хоорондоо ялгарч, уншихад хялбар ойлгомжтой байх
- ❖ Үзүүлэлтүүдийг дүрсэлж байгаа таних тэмдэг нь график дүрслэлийн хувьд өндөр нарийвчлалтай, зөв байх, уншихад хялбар, тодорхой байх.

